

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
GIZ	Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/631
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтэд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Алтансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үндсэн хөрөнгийн худалдан авалтын талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 24-нээс 2020 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/09 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ хийж, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах”-д оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудлаар эрдэм шинжилгээний суурь судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа хийх, ажиллах хүчний хэтийн төлөвийг тодорхойлох, шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Цалин хөлс, хөдөлмөрийн норм, норматив, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох асуудлаар суурь судалгаа, шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Хөдөлмөрийн эрх зүйн акт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хөдөлмөрийн нөхцлийн асуудлаар салбарын яам, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, судалгаа, шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Нийгмийн даатгал, тэтгэврийн бодлого, итгэлцүүр, сангийн удирдлагын асуудлаар эрдэм шинжилгээний суурь судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Олон улсын байгууллага болон тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн нэгж, үндэсний судалгаа, шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн

тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүнгээс сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 709,673.9 мянган төгрөгөөс тооцон 7,096.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн тооцоололд өөрчлөлт ороогүй байна.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,818.1 мянган төгрөгөөр буюу 75.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	257,8	-	(257,8)
Бараа материал	31,085.5	32,329.1	1,243.6
Үндсэн хөрөнгө	189,011.1	134,207.3	(54,803.8)
Нийт хөрөнгө	220,354.4	166,536.4	(53,818.0)
Өр төлбөр	2,000.0	-	(2,000.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	218,354.5	166,536.4	(51,818.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	220,354.5	166,536.4	(53,818.1)

2019 оны эхэнд 257.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай байсан бөгөөд тайлант хугацаанд барагдуулсан.

Бараа материалын эхний үлдэгдэл 31,085.5 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд бичиг хэрэг, аж ахуй, шатахуун, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн зардалд нийт 32,329.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 32,329.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант жилд 54,803.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 166,536.4 мянган төгрөг болж 53,818.1 мянган төгрөгөөр буурсан нь 2018 оны өглөг, тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 9,319.1 мянган төгрөгийн бичилт нь санхүүгийн үр дүнгийн тайланг бэлтгэхдээ аккруэл зарчмаар бүртгээгүйтэй холбоотой байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд 586,349.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 577,029.9 мянган төгрөгийг зарцуулан 9,319.2 мянган төгрөгийг хэмнэж, 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар GIZ-ээс 29,303.0 мянган төгрөг, Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс 39,523.3 мянган төгрөг нийт 68,826.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс сургалтын зардалд 29,174.6 мянган төгрөг, Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд судалгааны санхүүжилт, хяналтын зардалд 39,523.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 10,298.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9,319.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 979.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

Улсын төсвийн санхүүжилтийн орлогын дүнгээс төвлөрүүлэн шилжүүлсэн 9,319.1 мянган төгрөгийг бууруулж бүртэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 5 дугаар зүйлийн 5.3-р заалт "Үр дүнгийн тайланг гаргахдаа аккруэл суурьт үндэслэн гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Аудитын явцад санхүүгийн үр дүнгийн тайланг залруулав.

Аудитаар илэрсэн 979.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт, түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийт 1 зөвлөмж өгч зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 979.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний төлөвлөлтийн үе шатанд тооцсон 7,096.7 мянган төгрөгийн материаллаг түвшингийн дүнгээс бага тул Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Тайлант жилд 979.8 мянган төгрөгийн хөргөгч худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн нь бараа материалын тодруулга, **УСНББОУС17-ийн 13, 14** дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна;

3.1.2. Эрсдэл: Хууль тогтоомж, холбогдох стандартыг мөрдөөгүй байх;

3.1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг мөрдөж ажиллах;

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	31,343,401.00	32,329,163.00
33	АВЛАГА	257,850.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	257,850.00	-
33102	НДШ-ийн авлага	257,850.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	31,085,551.00	32,329,163.00
35400	Хангамжийн материал	31,085,551.00	32,329,163.00
35410	Бичиг хэргийн материал	8,326,477.00	11,418,992.00
35420	Аж ахуйн материал	108,000.00	84,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,248,945.00	5,298,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,175,000.00	2,868,000.00
35490	Бусад хангамжийн материал	19,227,129.00	12,659,671.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	189,011,177.42	134,207,304.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	189,011,177.42	134,207,304.34
39200	Биет хөрөнгө	122,493,887.94	88,925,414.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	163,377,700.00	163,377,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(153,212,234.83)	(162,252,700.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	237,878,479.27	237,878,479.27
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(203,626,314.04)	(213,006,703.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161,646,189.89	161,646,189.89
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(89,120,932.35)	(104,268,551.19)
39217	Номын фонд	5,551,000.00	5,551,000.00
39300	Биет бус хөрөнгө	66,517,289.48	45,281,890.28
39301	Програм хангамж	84,882,930.00	84,882,930.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(18,365,640.52)	(39,601,039.72)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	220,354,578.42	166,536,467.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	2,000,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,000,000.00	-
41300	Өглөг	2,000,000.00	-
41360	Бусад өглөг	2,000,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,000,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	218,354,578.42	166,536,467.34
51	Засгийн газрын хувь оролцоо	218,354,578.42	166,536,467.34
51200	Хуримтлагдсан үр дүн	218,354,578.42	166,536,467.34
51210	Өмнөх үеийн үр дүн	3,475,016,244.07	218,354,578.42
51220	Тайлант үеийн үр дүн	(3,256,661,665.65)	(51,818,111.08)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	220,354,578.42	166,536,467.34

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	726,845,930.00	667,174,951.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,205,930.00	11,999,531.00
1200	Өмчийн орлого	99,205,930.00	11,999,531.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	99,205,930.00	11,999,531.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	99,205,930.00	11,999,531.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,640,000.00	655,175,420.00
1310	Улсын төсвөөс	541,140,200.00	586,349,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	541,140,200.00	586,349,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,499,800.00	68,826,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	86,499,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	68,826,320.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	779,323,292.88	718,993,062.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	779,323,292.88	718,993,062.08
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	762,942,038.32	707,709,305.90
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	463,441,698.00	462,171,674.03
210101	Үндсэн цалин	351,012,698.00	400,821,158.03
210102	Нэмэгдэл	40,307,000.00	38,749,716.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	27,027,000.00	18,054,000.00
210105	Гэрээт ажлын цалин	45,095,000.00	4,546,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,452,250.25	58,352,756.99
210201	Тэтгэвэрийн даатгал	39,478,291.03	39,731,306.12
210202	Тэтгэмжийн даатгал	3,837,609.32	4,653,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,144,099.95	3,723,058.00
210204	Ажилгүйдлийн даатгал	860,999.46	930,799.59
210205	Эрүүл мэндийн даатгал	8,131,250.50	9,313,693.27
2104	Хангамж, бараа материалын зардал	91,223,586.19	61,298,255.80
210401	Бичиг хэрэг	13,236,915.00	12,402,664.00
210402	Тээвэр, шатахуун	35,301,700.00	12,869,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,977,667.19	16,118,351.80
210404	Ном, хэвлэл	17,582,100.00	15,401,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,125,204.00	4,506,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,624,605.00	4,599,345.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,624,605.00	3,451,345.00
210604	Урсгал засвар	-	1,148,000.00
2107	Томиллолт, зочны зардал	7,818,500.00	10,642,000.00
210702	Дотоод албан томиллолт	7,818,500.00	10,642,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,583,080.00	42,840,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	39,651,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	739,710.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	322,370.00	262,565.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	455,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,798,318.88	67,804,989.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	640,000.00	406,177.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	12,594,939.00

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210914	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	132,808,318.88	54,803,873.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,381,254.56	11,283,756.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,381,254.56	9,319,156.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,381,254.56	9,319,156.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,964,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,964,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,204,184,302.77	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(52,477,362.88)	(51,818,111.08)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3,204,184,302.77	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	3,204,184,302.77	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,204,184,302.77	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(3,256,661,665.65)	(51,818,111.08)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	627,640,000.00	655,175,420.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,640,000.00	655,175,420.00
1310	Улсын төсвөөс	541,140,200.00	586,349,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	541,140,200.00	586,349,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,499,800.00	68,826,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	86,499,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		68,826,320.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	627,255,000.00	655,175,420.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627,255,000.00	655,175,420.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,873,745.44	643,856,263.82
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	463,441,698.00	462,142,025.30
210101	Үндсэн цалин	326,820,639.00	346,574,725.30
210102	Нэмэгдэл	55,490,059.00	74,581,300.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	36,036,000.00	36,036,000.00
210105	Гэрээт ажлын цалин	45,095,000.00	4,950,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,710,100.25	58,089,155.72
210201	Тэтгэвэрийн даатгал	39,736,141.01	39,473,455.72
210202	Тэтгэмжийн даатгал	3,837,609.32	4,653,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,144,099.96	3,723,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	860,999.46	930,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,131,250.50	9,307,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,343,567.19	47,550,997.80
210401	Бичиг хэрэг	13,959,200.00	15,100,880.00
210402	Тээвэр, шатахуун	34,919,700.00	13,612,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,977,667.19	16,118,351.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,487,000.00	2,719,566.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,274,600.00	7,002,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,274,600.00	3,274,600.00
210604	Урсгал засвар		3,727,800.00
2107	Томиллолт, зочны зардал	7,818,500.00	10,642,000.00
210702	Дотоод албан томиллолт	7,818,500.00	10,642,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,583,080.00	44,840,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		39,651,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	739,710.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	322,370.00	262,565.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	455,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,200.00	13,589,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,200.00	997,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	12,591,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,381,254.56	11,319,156.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,381,254.56	9,319,156.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,381,254.56	9,319,156.18
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	385,000.00	

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	385,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	385,000.00	
223	БУСАД ХӨРӨНГӨ	385,000.00	
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	385,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(385,000.00)	
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)		
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			3,475,016,244.07	3,475,016,244.07
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			3,475,016,244.07	3,475,016,244.07
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			(3,256,661,665.65)	(3,256,661,665.65)
8	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			218,354,578.42	218,354,578.42
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			218,354,578.42	218,354,578.42
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			(51,818,111.08)	(51,818,111.08)
16	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			166,536,467.34	166,536,467.34

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-		
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	586,349,100.00	577,029,943.82	9,319,156.18	98.4
2	УРСГАЛ ЗАРДАЛ	584,349,100.00	575,029,943.82	9,319,156.18	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,349,100.00	575,029,943.82	9,319,156.18	98.4
210	БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,349,100.00	575,029,943.82	9,319,156.18	98.4
2101	Цалин хөлс, болон нэмэгдэл урамшил	465,382,200.00	457,192,025.30	8,190,174.70	98.2
210101	Үндсэн цалин	354,764,900.00	346,574,725.30	8,190,174.70	97.7
210102	Нэмэгдэл	74,581,300.00	74,581,300.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,036,000.00	36,036,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,172,800.00	58,089,155.72	83,644.28	99.8
210201	Тэтгэврийн даатгал	39,557,100.00	39,473,455.72	83,644.28	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,653,900.00	4,653,900.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,723,400.00	3,723,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	930,800.00	930,800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,307,600.00	9,307,600.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,431,300.00	38,245,997.80	185,302.20	99.5
210401	Бичиг хэрэг	12,640,500.00	12,640,080.00	420.00	100.0
210402	Тээвэр шатахуун	6,768,600.00	6,768,000.00	600.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	16,301,200.00	16,118,351.80	182,848.20	98.9
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,721,000.00	2,719,566.00	1,434.00	99.9
2106	Эд хогшил, урсгал зардалын зардал	7,124,600.00	7,002,400.00	122,200.00	98.3
210601	Багаж техник хэрэгсэл	3,274,600.00	3,274,600.00	0.00	100.0
210604	Урсгал зардал	3,850,000.00	3,727,800.00	122,200.00	96.8
2107	Томилолт, зочны зардал	8,581,100.00	8,314,000.00	267,100.00	96.9
210702	Дотоод албан томиллолт	8,581,100.00	8,314,000.00	267,100.00	96.9
2108	Бусдаар гүйцэтгүүлэх, ажил үйлчилгээний төлбөр	5,654,900.00	5,188,565.00	466,335.00	91.8
210802	Аудит, баталгаажуулах, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	750,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	381,000.00	262,565.00	118,435.00	68.9
210805	Тээврийн хэрэгслийн оншилгоо	66,000.00	66,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	457,900.00	110,000.00	347,900.00	24.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,002,200.00	997,800.00	4,400.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,002,200.00	997,800.00	4,400.00	99.6
26	Төвлөрүүлэн шилжүүлэг		9,319,156.18		
261090	Төвлөрүүлэн шилжүүлэг		9,319,156.18		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
3	ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	586,349,100.00	577,029,943.82	9,319,156.18	
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,349,100.00	575,029,943.82	9,319,156.18	
310001	Улсын төсвөөс санхүүжих	584,349,100.00	575,029,943.82	9,319,156.18	

	ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,000,000.00		
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00		
12000	Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	-	0	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	40	40	0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	
610001	Төсвийн байгууллага	1	1	0	
62	Ажиллагсадын тоо	39	39	0	
620001	Удирдах ажилтан	7	7	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	0	
620003	Үйлчлэх ажилтан	12	12	0	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		-
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		68,697,920.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		68,697,920.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		68,697,920.00
210	БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		68,697,920.00
2101	Цалин хөлс, болон нэмэгдэл урамшил		4,950,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		4,950,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		9,305,000.00
210401	Бичиг хэрэг		2,460,800.00
210402	Тээвэр шатахуун		6,844,200.00
2107	Томилолт, зочны зардал		2,328,000.00
210702	Дотоод албан томилолт		2,328,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлэх, ажил үйлчилгээний төлбөр		39,523,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлэх, нийтлэг ажил үйлчилгээний хураамж		39,523,320.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,591,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		12,591,600.00
30	Нэр данс төсөл хөтөлбөрийн орлого		
300008	Олон улсын байгууллага, дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл		68,697,920.00
13	ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		68,697,920.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		68,697,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлого		68,697,920.00
12000	Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,	Аудитын код: САГ-2020/185/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Тайлант жилд 979.8 мянган төгрөгийн хөргөгч худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн нь бараа материалын тодруулга, УСНББОУС17-ийн 13, 14 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна;	979.8	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	М.Алтансүх Б.Пүрэвцэцэг
	Нийт	979.8			

